



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/196

Улаанбаатар хот

Бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 31 дүгээр зүйлийн 31.1.7 дахь заалт, Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.4 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 63 дугаар тогтоол, 2012 оны 61 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЛАХ нь:

1. Тулгар төрийн 2226 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 811 жил, Ардын хувьсгалын 96 жилийн ойн баяр наадмыг угтан дүүргийн нутаг дэвсгэрт Бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулсугай.

2. Бүх нийтийн их цэвэрлэгээнд хяналт тавих ажлын хэсгийг нэгдүгээр, хороод, аж ахуйн нэгж, байгууллага цэвэрлэгээ хийх хуваарь, удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Хуримтлагдсан хог хаягдлыг шуурхай тээвэрлүүлэхийг Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс /Б.Отгонхүү/, Нийтлэг үйлчилгээний газар-1, 2, 3, 4 /Ж.Мөнх-Од, Д.Нэргүй, Х.Өлзийхорол, Э.Хатанбаатар/-т, цэвэрлэгээний ажлыг хариуцсан хорооны нутаг дэвсгэрт зохион байгуулж аж ахуйн нэгж, байгууллага, иргэд оршин суугчдыг өргөнөөр хамруулж, хог хаягдлын үйлчилгээ үзүүлж буй Нийтлэг үйлчилгээний газар 1, 2, 3, 4 Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газартай хамтарч цэвэрлэгээ зохион байгуулахыг хороодын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Цэвэрлэгээ хангалтгүй хийсэн газруудад хяналт тавьж, холбогдох хуулийн дагуу захиргааны арга хэмжээ авч ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /А.Пүрэвдулам/, цэвэрлэгээний ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлахыг Хэвлэл мэдээллийн алба /Д.Цэнгэлмаа/-д тус тус даалгасугай.

5. Цэвэрлэгээний ажилд аж ахуйн нэгж, байгууллагуудыг өргөнөөр оролцуулах, хяналт тавих, мэдээг нэгтгэж дутагдалтай ажилласан хороо, байгууллага, аж ахуйн нэгжид авах арга хэмжээний санал боловсруулж танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Т.Батцогт/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВДАВАА